

ТҮҮХЧИЙН ИНДЭР

**ОЙРАД МОНГОЛЫН ТҮҮХЭЭС
ӨГҮҮЛЭХ ИНҮ****Чулууны Далай****Хоёр****Түрүүн дөрвөн ойрадын холбоо**

Ойрадын холбооны тухай анхны бодитой мэдээ Монголын нууц товчоо,¹ Рашид-адины судрын чуулганд² гардаг. Монголын их шар туужид худуга бэх бол хойдын ноён мөн. 5 дугаар Далай лам Агваан лувсанжамцын зохиосон залуусын хуримд худуга бэх бол хойдын ноён байсан гэх мэтээр тэмдэглэсэн байна. Түрүүн дөрвөн ойрадын холбооны тухай БНХАУ-ын ойрадыг судлагч эрдэмтэд ялангуяа Бадай, Алтан-Оргил нар «Ойрадын түүхэн сурвалж» зохиолдоо тодорхой бичжээ.

Байгаль нуурын хавийн өргөн уудам сав газарт мал маллахаас гадна гөрөөлөн загасчилан амьдардаг байсан олон монгол аймгийг Чингис хаан Их Монгол улсын бүрэлдүүнд хураан нэгтгэсэн билээ. Ингээд Чингис хаан ойрадуудыг дөрвөн мянгатын засаг захиргааны зохион байгуулалтад оруулжээ. Энэ байдлаас үзэхэд XII зууны эцэс гэхэд дөрвөн хэсгээс бүрдсэн дөрвөн Ойрадын эхлэл тавигдсан байж болох юм.

XIII зууны эхэн үед Байгалийн баруун сугаас цааш нутаглаж байсанг Ойрад, Байгалийн зүүн биеэр нутаглаж байсанг Барга, Буриад гэж нэрлэж байсан ажээ. Байгаль нуурын сав газраар нутаглаж байсан тэдгээр ард түмнүүдийн дотроос дөрвөн Ойрадын холбоо анх үүссэн бололтой юм. Ойрадын түүхийг сайн судалсан Өвөрмонголын Алтан-Оргил, Шинжааны Норов багш нар бас ийм үзэл баримтлалтай байдаг ажээ. Ойрадын гарал үүслийн талаар бичгийн зохиол ховор боловч аман домог яриа цөөн бус юм. Гарал үүслээ домгоор нэгтгэн илэр хийлдгээрээ ойрад хүмүүс онцлогтой юм. Энэ талаар ойрад Монголчуудын дотор нэлээд өргөн дэлгэрсэн нэгэн домгийг авч үзье. Эрт урь дын цагт Амунэ, Домунэ³ гэдэг нэртэй хоёр хүн байжээ. Хоёулаа өдөр ой модоор гөрөөлөн явж байтал цорго хэлбэртэй нэгэн модны дор Нялх хөвгүүн модны шүүсээр хооллон хэвтэж бяцхан ууль шувуу түүнийг сахиж байжээ. Хоёр анчин дээд тэнгэрээс заяасан хүү хэмээн түүнийг авч гэртээ харьжээ. Хөвгүүн өсөөд том болж, тэдний ноён суужээ. Цорго хэлбэртэй модны дор байсан учраас хүүгийн захирсан аймгийг цоргос (Цорос) овогтон болгожээ. Чухам ингэж Цорос овог бол дөрвөн ойрадын тэргүүлэх ястан болжээ. Амунэ нь 10 хөвгүүн төрүүлж үр удам нь өсөөд Өөлд, Зүүнгар болж, Домунэгийн дөрвөн хөвгүүн өсөн үржиж Дөрвөд аймаг болсон гэнэ. Өөр хоорондоо төсөөтэй иймэрхүү домог Ойрад Монголын дотор нэлээд тархсан байдаг. Энэ домгийг янз бүрээр хэлдэг.⁴ Зарим сурвалжид янз бүрээр ч бичсэн бий.⁵ Амунэ, Домунэ хоёр зарим үед анчин эр ч болдог. Зарим хувил барт эм хүн ч болж гардаг. Энэ бол уул домгийн гарал үүсэл их эртнийх болохыг харуулж байна. Хүй нэгдлийн эхийн эрхт ёсны үед үүсч домгийн баатар нь эм хүн байгаад эцгийн эрхт ёсны үед эр хүн болсон байж ч болох.

Уд модны шүүсээр тэжээл хийж, ууль шувууны дэргэд өссөн хөвгүүнийг хүн олж аваад «Уд модон эхтэй, ууль шувуун эцэгтэй, удамтай Цорос, урамтай Бадам»⁶ гэж нэр өгсөн гэнэ. Модны дор өлгөөтэй хэвтэж байсан тэнгэрийн дагины тэр хүүг үргүй эмгэн, өвгөн олж тэжээсэн гэж ч ярьдаг. Галданы Эрдэнийн эрихэд ингэж тэмдэглэсэн буй.

Аман уламжлал ба бичгийн түүхээс үзвэл Ойрад Монголчуудын өвөг дээдэс эртнээс нааш Байгаль нуур, Сэлэнгийн адаг, Тагна, Соёны нуруу, Горлог (Енисей), Эрчис мөрний эх, Алтайн уулсын ой тайгад оршин сууж мал маллахаас гадна ан гөрөөгөөр амьдарч байжээ. Түүхэнд тэднийг хорь түмэд, Баргуд, Булгачин, Хэрэмчин, Урианхайд гэх мэтээр тэмдэглэсэн байдаг. Урианхайчууд бол Ойрад Монголын гол өвөг дээдэс болж явсан түүхтэй бөгөөд IX зууны үед Бурхан Халдун нутагтай Монгол урианхайн түүх тодорхой болсон юм.

Чингис хаан Найманыг дайлахад Ойрадын зонхилогч Хутуга Бэх Найманы Даян хааны талд түр орж Чингисийн эсрэг тэмцэж байгаад сүүлдээ ухаарч Даян хаанаас салсан юм. Тэрээр Чингисийн цэргийн хүч чадлыг нүдээр үзэж урьдаас нь гар сарвайх аргагүй гэдгийг нэгэнт мэдсэн байжээ. Тийм ч учраас Чингисийн ууган хүү Зүч ойн иргэнийг нэгтгэхээр дайтахад зонхилогч Хутуга бэх эсэргүүцэл үзүүлээгүйгээр барахгүй Зүчийн цэргийг замчилж байсан удаатай.⁸ Харин 1217 онд ойн иргэдийн дотор Хорь Түмэд тэргүүлэн бослого гарахад Зүч очиж хатуу цээрлүүлэн дарсан байна. Тэр үеэс ойрадууд баруун тийш нүүдэлж, Алтайн уулсын ар өврөөр голчлон нутаглах болжээ. Чингис хаан харъяат Ойрад, Урианхай аймгийг Зүчид өвлүүлж дотор нь засаг захиргааны дөрвөн нэгж-дөрвөн мянгатан болгожээ. Чухам энэ үеэс дөчин түмэн монгол, дөрвөн түмэн Ойрад гэдэг нэр томъёо гарсан бололтой. Өөрөөр хэлбэл дөчин, дөрвөний холбоо үүссэн ажээ. Гэхдээ мянгат гэдэг нь мянгаар хязгаарлагдах тооны нэр биш засаг захиргаа ны том нэгж байжээ. Чингисийн үед Ойрадыг Урианхай гаралтай Сүбэдэй, Зэлмэ нар голчлон захирч байгаад Өгөөдэй хааны үе хүрэхэд Гүюгийн мэдэлд оржээ. Өгөөдэйн хүү Гүюгийн ухаант хатан бол Хутуга бэхийн охин Огулкаймиш байсан бөлгөө. Энэ үеэс урианхайчуудын Чингисийн удамд хамгийн үнэнч зүтгэгч хэмээн Монгол хаадын цогцсыг нууцлан хадгалдаг Онгон уул Бурхан-Халдунаар нутаглуулж халдашгүй эрх дарх олгожээ. Энэ нь Зэв, Сүбэдэйн үйл ажиллагаатай ч холбоотой байж болох юм.

Юан гүрний үед монголын их хаан ширээ Тулайн угсаанд бүрмөсөн шилжсэнээс болж Өгөөдэй, Тулайн угсааны хооронд цус асгаруулсан тэмцэл үүсч олон арван жил талцан байлдав. Тэр үед ойрадууд нь Өгөөдэйн угсааны Аригбөх, Хайдуу нарын тэмцлийг дэмжиж байв. Тулайн хатан Сурхагтани Алтай нутаг дахь өөрийн хувь газрыг Аригбөхөд эзэмшүүлэхээр өгсөн юм. Тэр үед Ойрад монголчууд Монголын нийслэлийг Хархорумаас нүүлгэхийн эсрэг, хятадаар төвлөсөн Юан гүрэн байгуулахын эсрэг зогсож байв. Аригбөх, Цагаадайн ач Хархул ноён Ойрадын ноёдын охиныг эхнэр болгон авчээ.

Ойрад Монголын газар нутаг, хүн ард, эд агуурсыг түшиглэн Хубилайн эсрэг тэмцэж байсан Аригбөх, Хайдуу нарын тэмцэл 1305 онд үндсэндээ ялагдаж Ойрадын нутгийг тастан хувааж хүн ард нь тархаж эхлэв. 1307 онд Давааны арын орон тусдаа эрх мэдэл бүхий болох үед ойрадууд түүнд харьяалагдах болов. Гэхдээ Хаан балгасан төвтэй Юан гүрний эсрэг тэмцлээ зогсоогоогүй юм.

1368 онд Юан гүрэн мөхсөний дараа гадаад дотоодын элдэв хүчний хавчлагад өртөгдөн ойрадчууд нэгдэн нийлэх хүсэл эрмэлзэл дүүрэн байв. Тэр үед Ар Юан Монгол улс болон Хятадын Мин улсын хоо-

ронд ширүүн дайн болж байв. Дайны хөлөөс зугатсан монголчууд ойрадын нутагт очиж амь зуух нь олон болов. Чухам ингэж дөчин, дөрвөн хоёр холилдон амьдрах нь их болон. Юан гүрэн мөхөж байх үед монгол гүрэн бүрмөсөн задарч баруун азийн Ил хаант улс, дунд азийн Цагаадайн хаант улс, өрнөдийн Кивчакийн хаант улс тус бүр задран сарнисан байв. Тэдгээрийн улсын зарим нутгаар Ойрад Монголчууд нутаглах болов. Гэвч Чингисийн угсааны язгууртан нар ээлжлэн хаан сууж, улс орноо тохинуулахад Ойрадыг эрхэндээ оруулах гэж тэмцсээр байв. Энэ үед ойрадын Мөнх Төмөр ноён бүх Ойрад Монголыг нэгтгэн захирч ихэд хүчирхэгжив. Хятад болон Төвд сурвалжаас үзвэл Хойдын явган мэргэн буюу Төмөрлан бол Мөнх Төмөрийг хэлж байсан бололтой. 1400 онд Монголын Гүн Төмөр хаан ойрадын Мөнх Төмөртэй эвийн холбоо байгуулж Мин улсын довтолгооны эсрэг хамтран тэмцэж байжээ.⁹ Удсангүй 1402 онд Гүн Төмөр хаан нас баржээ. 1405 онд Мөнх Төмөр ноён их цэргийн хүчээр Мин улстай байлдаж яваад өвчнөөр нас баржээ.¹⁰ Чухам ингэж Гүн Төмөр хаан, Мөнх Төмөр ноёны нэгдсэн холбоо тасарч ойрадууд биеэ даасан шинжтэй болжээ. 1403 онд Гүн Төмөр хааны дүү Гүйлэс хаан ширээ залгаж Өлзий Төмөр хаан хэмээн өргөмжлөгдөв.¹¹ Энэ үеэс Дорнод Монгол, Ойрад Монгол хоёрын хооронд тэмцэл хурцдаж улмаар хоорондоо дайтсан юм. Өлзий Төмөр хаан Тамирын голын урсгал дагуу ойрадын цэрэгтэй тулалдсан тухай мэдээ сурвалжид гардаг. 1407 онд Гүйлэс хаан ширээнээс огцорч Буяншир хаан суув. Дорнод Монгол, Ойрад Монголын хоорондын зөрчил тэмцлийг Мин улсын ноёрхогчид овжноор ашиглан, хоёр хүчний дунд элдвээр яс хаян «нүүдэлчдийг нүүдэлчдээр», «монголчуудыг монголчуудаар» цохиулах гэдэг Хятадын эзэрхэг түрэмгийчүүдийн уламжлалт харгис бодлогыг идэвхтэй явуулж, Монгол улсын нэгдмэл хүчийг сарниан сулруулах ажлыг хийжээ. Тэд энэ бодлогондоо юуны түрүүнд Ойрадын ноёдыг эхлэн ашигласан юм. Ингээд 1409 онд Мин улсын хаанаас Ойрад Монголын гурван хүчирхэг ноён-Цоро сын Бухан, Торгуудын Тайван (Амгалан), Хэрнүүн Ойрадын Батболд¹² нарт «Ван» цол хүртээж,¹³ тэдний монгол улсын бүрэлдүүнээс салан гарч тус тусдаа вант улс байгуулах гэсэн санааг далдуур өөгшүүлэн дэмжиж Монгол улсын хүчийг сулруулах ажил хийж байв. Цорсын Бу Хан гэдгийг Монгол сурвалжид Бахаму, Хятад сурвалжид, Махаму гэж тус тус тэмдэглэжээ.¹⁴

Ойрадын феодалуудын энэхүү үйл ажиллагааг нийт монголчуудын эрх ашиг, нэгдмэл улс байх гэсэн хүчин чармайлтын үүднээс авч үзвэл арга буюу тухайн үедээ сөрөг үйл ажиллагаа байсан байна. Гэхдээ ойрадын ноёдын үйл ажиллагаа нь түүхэнд тэмдэглэсний адил дан ганц салах гэсэн оролдлого биш байв.

Ойрадын Махаму ноён тасран салах биш бүх монголыг нэгтгэх нь зүйтэй гэдэг бодлогыг баримталж эхэлмэгц хятадын Мин улс Дорнод Монголын талд орж Махаму тэргүүтэй Ойрадын хүчийг цохиж эхлэв. Ингэж ойрадын хүчийг сулруулахын тулд Юан Лэ хааны биеэр удирдсан их цэрэг 1414 онд Туул гол хүртэл Ойрадыг нэхэн байлдаж Улаан хошуу гэдэг газар хүчтэй тулалдаж хоёр талдаа их хохирол үзжээ. Дорнод Монголын дотор Чингисийн угсааны Буяншир хааныг ойрадууд алсан гэдэг худал цуу тарааж, түүнийгээ хэрэгжүүлэхээр түүх судартаа хүртэл тэмдэглэн шургалуулж амжсан билээ. Үүнээс болж олон эрдэмтэн түүх сударт Буяншир хааныг Ойрадын Махаму барьж алсан гэж андуу ташаа бичих нь үзэгдэх болсон юм. Харин Саган Сэцэн зэрэг монгол түүхчид өвчнөөр үхсэнийг нь үнэн мөнөөр бичжээ.

1418 онд Тогоон (1418—1434) эцэг Батболдын суурийг залгамжлахаар гарч ирэв. Өөрөөр хэлбэл монголын түүхэнд дөчин, дөрвөний харилцаа хүчтэй болж, дөрвөн Ойрадын түүх нэн тодорхой болжээ. Гэвч эцэг Батболдыг байх хугацаанд Тогоон тайш түүнд захирагдсан хэвээр байв. 1424 онд Батболдыг Хорчины Аругтөмөр алав.¹⁵ 1425 онд Аруг Төмөр өөрийгөө Адай хаан хэмээн өргөмжлөв. Мин улсын хаанаас бас л Ойрадыг биедээ татах гэж Тогоонд «тайш» хэргэм хүртээжээ. Энэ үед Ойрад Монгол нь хүчирхэг болж, төв Монголтойгоо байн байн дайтаж бас Дорнод Цагаадайн хаант улстай 1418—1428 он хүртэл бүгд 61 удаа их бага хэмжээний дайн хийж ялалт олжээ. Тогоон тайш бол тухайн үедээ Монголын ноёрхогч ангийн дотор хамгийн ухаалаг том улс төрийн зүтгэлтэн байжээ. Тогоон тайш төв монголоос ойраддоо буцах үед монголын байдлыг нэн уран үгээр дүрслэн бичсэн байдаг.¹⁶ Ойрадын хүч их болж бүх монголыг нэгтгэх боломжтой болоод ирэхтэй зэрэг Хятадын Мин улс дахиад л Ойрадуудаас урваж, Дорнод Монголын талд орж, Ойрадын эсрэг дорнод төв Монголын хүчийг тухирав.

Түүхийн ээдрээтэй тэр хугацаанд Ойрадын ард түмэн «Хятадын бодлого» гэгчийн хор холбогдлыг бүрэн ойлгож, харийн эзлэн түрэм гийлэгчдийн эсрэг тэмцэлд шийдвэртэй зогссон байна. Тогоон тайшийн үед Тогтохбухын сүр хүч доройтож монголын засаг төрийн эрх Ойрадын Тогоон тайшийн гарт бараг шилжихэд хүрчээ. Өөрөөр хэлбэл Тогтохбух бараг л Тогоон тайшийн мэдэлд шахам байжээ.

1437 онд Адай хаан Тогоон тайштай байлдаж ялагдаад зугадаж яваад нас баржээ. Ингэж Тогоон тайшийн санаачлагаар Тогтохбухыг Монголын хаанд өргөмжилж өөрийгөө удаахь тайш болгов. Энэ үеэс түрүү дөрвөн ойрадын холбоо зүй ёсоор бий болсон гэдэг.¹⁷

1442 онд Мин улсын Ин Зун хаанаас Солонгосын ванд бичсэн нэгэн бичигтээ: «Умарт улсын Тогтохбух боловоос түүний эрхт түшмэл Тогооноос болгоосон хоосон нэр төдий л хоосон эзэн хаан мөн. Монголын жинхэнэ засаг төрийн эрх нь Тогооны гарт байсан билээ» гэж дурьджээ. Мөн Мин улсын Ин Зун хаанаас Монгол улсын засаг төрд бичиг илгээхдээ Тогтохбух хаан, Тогоон тайш хоёрын нэрийг зэрэгцүүлэн бичдэг байжээ.¹⁹

Тогоон тайшийн үед монгол туургатан нэгэн хааны захиргаанд нэгдэн нийлж эхэлсэн байв. Тэр үед дөрвөн ойрадын холбоог урианхай гаралтай Цоросууд захирч байв. Цоросын ноёд бол Чингис хааны үеийн Аданхан Урианхайны Жарчудайн хүү Өрлөг Зэлмийн үрийн үртэс юм. Цорос Ойрадын Тогоон тайш ийнхүү Хэрэнүүдүүдийг мөхөөж, торгуудыг эрхшээлдээ оруулж хошуудыг буулган авчээ. Ингэж түрүү дөрвөн ойрадын холбоог бүрдүүлэв. Түрүүн дөрвөн ойрадын тухай Монгол сурвалжид тэмдэглэсэн нь: Нэгд, Цорос, Торгууд, Хошууд нийлж нэг Ойрад; хоёрт, Түмэд, Хойд, Бадууд нийлж нэг Ойрад; гуравт, Барга, Буриад нийлж нэг Ойрад; дөрөвт, Үр монгол нийлж нэгд Ойрад болно гэжээ.²⁰ Түрүүн дөрвөн ойрадыг Цорос гэдэг ерөнхий нэрээр төлөөлүүлэн хэлдэг ёс байжээ. Түрүү дөрвөн Ойрадын нутаг нь Алтайн уулсаар савалж зүүн тийшээ, Орхон туулд хүрдэг байжээ.

1439 онд Тогоон тайш нас барж хүү Эсэн (1439—1455) суурийг залгамжлав. Эсэний үед Ойрадын хүч улам их болж Тогтохбух хааны эрх мэдэл гэж бараг байхгүй, засгийн бүх эрх Эсэний мэдэлд бүрмөсөн шилжжээ. Эсэн хааны монголын түүхэнд гүйцэтгэсэн гол үүрэг бол бүх монголын хүчийг нэгтгэж, түр боловч нэгдмэл монгол улс байгуулж, хятадын Мин улсын цэргийн түрэмгийлэл, монголын хүчийг сарниулах талаар явуулж байсан хорт бодлогод хүчтэй цохилт өгсөн

явдал юм. Эсэн бол цэрэг улс төрийн нэрт зүтгэлтэн байжээ. Бас тэгээд тэрээр гадаад харилцааны өндөр соёл эзэмшсэн байжээ.²¹

1449 онд Эсэн хаан хоёр түмэн морин цэргийн хүчээр Мин улсын хааны 50 түмэн морин, явган цэрэгтэй «Ту-му» (Монголоор том буу) гэдэг газар ширүүн тулалдаж, Хятадын цэргийг бут цохиж, Ин Зун хааныг нь 8-р сарын 15-нд олзолжээ. Энэ нь Хятадын түүхэнд «Тү му-гийн хэрэг» гэж тэмдэглэгдсэн байна. Эсэний цэрэгт бут цохигдсоны дараа Хятадын Мин улсын язгууртан феодалын дотор үймээн дэгдэж, монголчуудаас айх эмээх нь улам их болжээ. Мин улсын хааныг Монголчууд нутагтаа жил шахам хугацаагаар хүндэтгэлтэйгээр байлгаж байгаад гадаад харилцааны нарийн ёс дэглэмтэйгээр буцааж хүргүүлсэн билээ. Гагцхүү монгол улсыг дахин довтлохгүй гэдэг ам тангарагийг Хятадын эзэн хаанаас авсан юм. Энэ үеэс Мин улсын хилийн харуулын сүр хүчин доройтож, цэргийн санаа сэтгэл их алдагджээ. Өөрөөр хэлбэл Монголчуудыг цэргийн хүчээр давамгайлж яасан ч болохгүй, зөвхөн муу заль мэхээр үзэхээс өөр ямар ч аргагүй гэдгийг Мин улсын хаан биеэрээ мэдэрч ойлгосон байна.

Юан гүрний дараа Хятадын Мин улсын зэвсэгт түрэмгийлэлд анх удаа үхлийн цохилт өгч, монголын тусгаар тогтнолыг тууштай хамгаалсан хүн бол Ойрад Монголын Эсэн хаан мөн байжээ. Эсэн 1454 онд өөрийгөө бүх монголын хаан хэмээн өргөмжилсөн тухайгаа хятадын Мин улсын хаанд албан ёсоор мэдэгджээ.

Мин улсын хаан Эсэнг бүх Монголын хаан гэж аман дээрээ зөвшөөрсөн боловч цаагуураа зөвхөн Ойрадын хан гэдэг утгаар албан баримтдаа тэмдэглэжээ.

Мөн түүнчлэн Мин улсаас Эсэн хааны эсрэг яс хаясан өдөөн хатгалгыг дорнод монголын ноёдоор дамжуулан хийж, нийт монголчууд дотор Эсэн бол «Чингисийн угсааны хаан суух хүн биш» гэдэг үзлийг дэвэргээн зарлажээ. Тухайн үед Эсэн хаан өөрийн гавьяат сайд Алаг Төмөр нарыг гомдоож ил, далд эсэргүүцэлтэй бас тулгарчээ. Энэ бүхнээс шалтгаалж Эсэн бүх Монголын хаан ширээнд удаан сууж чадсангүй ялагдав. Үүнээс хойш Ойрад Монголын нэгдмэл хүч дахин сарнин бутрав.

Эсэнийг Монголын зарим түүх сударт ардууд цохиж алсан, Сорсон түшмэлийн есөн хүүд алагдсан гэх мэтээр цуурхал дэгдээсэн байдалтай тэмдэглэл ч бичиж үлдээсэн байдаг. Үүнийг хойшид нарийвчлан судалж жинхэнэ үнэн мөнөөр бичих нь зүйтэй юм.

Түүхийн ихэнх сурвалжийн мэдээнээс үзвэл, Эсэн хааны хятадын Мин улсын түрэмгийллийг сөрөн зогссон бүх монголыг нэгтгэн нэгэн хааны захиргаанд оруулах гэсэн тэмцлийг тухайн үед Дорнод монголын зарим феодалууд, улсын хэргээс урвасан Алаг чинсан мэтийн ойрадын зарим нэг ноёдоос бусад бүх монголчууд дэмжиж байсан байна. Мөн Эсэн хааны улс төр, цэргийн гарамгай бодлогоос болж Хятадын Мин улс Монголыг цэргийн хүчээр довтлохоо зогсоож Монгол улсыг Мин улстай эрх тэгш, эн зэрэгцсэн улс хэмээн хүлээн зөвшөөрсөн явдал юм. Энэ бол Эсэнгийн Монголын түүхэнд гүйцэтгэсэн дэвшилттэй гавьяат үйл ажиллагаа мөн. Эсэн хаанаас хойш Ойрадын түүх нэг хэсэгтээ (150 гаруй жил) нэлээд балархай болжээ.

Түүрүүн дөрвөн Ойрадын холбоо нь 1437 оноос 1502 он хүртэл 65 жил баттай тогтож байгаад задралын байдалд оржээ. Энэ хугацаанд Их дөрвөн Ойрад, Ойрадын хаант улс, бага дөрвөн Ойрад зэрэг гурван шат өнгөрүүлсэн ажээ.

1. Монголын нууц товчооны 10 дугаар бүлэгт Ойрадын олон аймгийн тухай гардаг. Баяр. «Монголын нууц товчиан» Хөх хот., 1981, гудгаар дэвтэр, 1140—1141-р, 1146-р талууд
2. Рашид-ад-Дины «Сударын чуулган» зохиолын тэргүүн дэвтэрт Ойрадын гарал үүслийн тухай тодорхой мэдээ бий. Домгийн зүйлс ч бий.
3. Амунэ, Домунэ хоёр нэрийг Эмүнэ, Дэмүнэ гэх мэт янз бүрээр бичдэг.
4. Олон янзын хувилбар домог бий. Торгуудууд нэг янз, Цорос, Ойрад, Захчингууд нэг янз, Дөрвөд бас өөрөөр ярьдаг. Гэхдээ агуулга адил. Дөрвөд ардын дотор их дэлгэрсэн «Тэнгэрийн дагина» хэмээх домогт хамгийн тодорхой яригддаг.
5. Галдан— «Эрдэнийн эрих» 76-р талд, Д. Сэнгэрэнцэн Монголын шидэт үлгэр» 1990, Хөх хот, 164—165-р тал. Бадай, Алтан-Оргил нар «Ойрадын түүхэн сурвалж бичиг, 1985, Хөх хот. 185—186-р 237—238-р талууд, Монгол үндэстний утга «зохиолын материалын эмхэтгэл» нэгдүгээр дэвтэр, «Тэнгэрийн ач» хэсэг
6. Д. Сэнгэрэнцэн «Монголын шидэт үлгэр» 164-р тал
7. Гаван Шаравын тууж хэмээх оршивой, «Ойрадын түүхэн сурвалж бичиг», 234-р тал
8. Түүхчин Нямбуу Ойрадын тухай Улаан-Од сонинд сонирхолтой өгүүлэл бичиж нийтийн хүртээл болгов.
9. «Мин Тай-цзун ши-лу» (Мин улсын Тай Цзун хааны үнэн тэмдэглэл); Саган сэцэн «Эрдэнийн товч», Хөх хот, 1981, 285-р тал, «Алтан товч» Хөх хот, 1983, 556-р тал, Мөн Шар тууж зэрэг олон монгол сурвалжид Мөнх Төмөр тэргүүтэй Ойрадын ноёд 1400 он хүртэл Монгол хааныхаа талд хатуу зогсож Мин улстай тэмцэж байсан тухай сонирхолтой мэдээнүүд байна.
10. Ойрадын түүхэн сурвалж, 36-р тал
11. Мин Тайцзу ши-лу»-ийн 1402 оны хэрэг явдал дотор тодорхой тэмдэглэл бий.
12. Дээрх сурвалжийн 1408 оны гуравдугаар сарын цагагчин тахиа өдрийн тэмдэглэл, мөн 1409 оны тавдугаар сарын хөхөгчин хонин өдрийн тэмдэглэлд үз. «Ойрадын түүхэн сурвалж» 37-р тал
13. Батболдыг Монгол сурвалжид Батала чинсан гэдэг. «Алтан товч» 557-р талд, «Эрдэнийн товч» 283-р тал, «Хураангуй алтан товч» 67-р тал, «Шар тууж» 104-р тал, «Гангын урсгал» 81-р тал; Дээрх сурвалжийн БНХАУ-д хамгийн сүүлд хэвлэсэн эхээр иш татав.
14. «Хан тэнгэр» сэтгүүл, Үрэмч, 1983 оны 2-рт, 19-р тал
15. «Эрдэнийн товч» 290-р тал
16. Энэ тухай Алтан товчид бичсэн нь; «Монголын Аругтай тайш өтөлж, аливаа үйл уусгал мэт санагданам. Саадаг нь хувилж санаа нь эс хувилж, төр мэдэх сайдаа гадна суулганам. Зэвийн морийг гэр дээр уннам, өчүүхэн мэдэх хүнийг төрд явуулнам. Үрээ мориныг живлам. Босхуул хүнийг төр мэдүүлэн Борви хөхүүрт сархад хийнэм. Буургүй тэмээ, бухгүй үхэр, азрагагүй адуу, хуцгүй хонь мэт» гэжээ. «Алтан товч», 566-р тал
17. «Баатар Убааш түмний түүх»-д бичсэн нь: «Улаан залаат халимаг Ойрад, Өөлд гэдэг нэр хадсанаас эдүгээ шар туулай жил (1819) он хүртэл 382 жил болсон» гэжээ. Энэ нь яг л 1437 он болох юм. «Ойрадын түүхэн сурвалж», 41-р тал
18. «Ойрадын түүхэн сурвалж» 22-р тал
19. «Мин улсын Ин Цзун хааны үнэн тэмдэглэл» 100-р боть, 1443 оны цагаан сарын хар морин өдрийн тэмдэглэлд
20. «Ойрадын түүхэн сурвалж», 42-р тал
21. Одон, «Эсэн хаан», Хөх хот, 1988, Энэ номонд Эсэн хааны тухай товч бөгөөд тодорхой бичжээ.

Үргэлжлэл бий